






7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4	5	4	4	5	4	5	4.4	Хангалттай	
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	Хангалттай	
<b>Нийт оноо</b>		<b>100</b>									<b>90.1</b>	

**Ажлын хэсгийн дарга:** Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга  /Д.Мөнх-Эрдэнэ/


**Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:** Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн  /Н.Намуунцэцэг/

**Гишүүд:** Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч /О.Долгион/

Умард говийн гүвээт, халхын дундад талын сав газрын захиргааны мэргэжилтэн  /Н.Солонго/

Сүмбэр сумын ЗДТГ-ын Байгаль орчны мэргэжилтэн  /Б.Уранчимэг/

Сүмбэр сумын Байгаль хамгаалагч  /С.Түмэндэлгэр/

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл  /Н.Маралгуу/

**Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

“Батганжир” ХХК-ийн гүйцэтгэх захирал



/Х.Цэнгэлбаяр/

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2022.12.29

Говьсүмбэр аймаг

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжаар байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгаж дүгнэлт гаргах байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 оны 12 сарын 23-ны өдөр “Батганжир” ХХК-ийн “Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлантай газар дээр нь танилцаж үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх явцад гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай дараах ажлуудыг зөвлөмжилж байна. Үүнд:

1. “Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийчилсан үнэлгээний тайлантай сайтар танилцаж төслөөс үүсэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээг бодитой төлөвлөх
2. Нурмаг ачаа болон ачилт буулгалтын үед үүсэх тоос, тоосонцорыг бууруулах зорилгоор тоос, тоосонцороос хамгаалсан зориулалтын торон хашаа барих
3. Хөрсний элэгдэл, бохирдлоос сэргийлж төслийн талбайг хатуу хучилттай болгох
4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхитэй оролцож 2000-аас доошгүй мод шинээр тарих, түүнд зарцуулагдах хөрөнгийг бодитой тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
5. Мод, бут тарихдаа мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж авч орон нутгийн хөрс болон цаг агаарын онцлогт тохирсон мод бут тарих, ургуулах, шинээр таригдсан модыг сумын мэргэжилтэн, байгаль хамгаалагчийг оролцуулан тоолж акт үйлдэн баталгаажуулах
6. Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ын дагуу аюултай хог хаягдлыг /машин механизмын төмрийн хаягдал, дугуй, тосны шүүр, аккумулятор, тос, тосолгооны материалын хуванцар сав, тостой даавуу гэх мэт/ түр хадгалж аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагад шилжүүлж бүртгэл хөтлөх

7. Энгийн болон аюултай хог хаягдал, дахивар хог хаягдлыг ангилан ялгаж аюултай хог хаягдлыг журамд заасны дагуу түр хадгалах, шилжүүлэх, дахивар хог хаягдлыг дахивар авах цэгт хүргэх, дахин боловсруулах боломжгүй хаягдлыг орон нутгийн зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр тээвэрлүүлэх

8. Хог хаягдлын тухай хуулиар аж ахуйн нэгж, байгууллагыг хөрс бохирдуулагч жорлон байгуулахыг хориглосон тул төслийн талбайд байрших нүхэн жорлонг ариутгал хийн булж устгах, шинээр Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2005 стандартын шаардлага хангасан доторлогоотой жорлон байгуулах

9. Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан Хогийн саванд тавигдах шаардлага-ын дагуу ангилан ялгах хогийн сав байршуулах

10. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаар, хөрсний шинжилгээ авах цэгийн байршил, хугацааг тодорхойлж Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж хүнд металлын агууламжийг тодорхойлуулах

11. Шинээр гаргасан худагт усны баталгаат тоолуурыг мэргэжлийн байгууллагаар суурилуулж Байгаль орчин, аялал жуулчлалын газраар ус ашиглуулах дүгнэлт гаргуулах

12. Эзэмшил газрынхаа гадаад орчны бүсэд цэвэрлэгээний ажил тогтмол зохион байгуулж талбайд ирж буй ачаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас үүсэж байгаа тоосыг бууруулах ажилд бусад ААН-тэй хамтран ажиллах


Дээрх зөвлөмжид тусгагдсан арга хэмжээнүүдийг 2023 оны БОМТ-д тусган хэрэгжүүлэх үүрэг даалгавар өгч ажлын хэсгийн бүрэлдэхүүн “Батганжир” ХХК-ийн “Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх аргачлалаар дүгнэж, хэрэгжилтийг 90.1 оноотойгоор үнэллээ.

**Ажлын хэсгийн дарга:** Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын

газрын дарга

 /Д.Мөнх-Ордэнэ/

**Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:** Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

 /Н.Намуунцэцэг/

**Гишүүд:** Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч /О.Долгион/

Умард говийн гүвээт, халхын дундад талын сав газрын захиргааны

мэргэжилтэн

/Н.Солонго/

Сүмбэр сумын ЗДТГ-ын Байгаль орчны мэргэжилтэн

/Б.Уранчимэг/

Сүмбэр сумын Байгаль хамгаалагч

/С.Түмэндэлгэр/

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл

/Н.Маралгуа/

**Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

“Батганжир” ХХК-ийн гүйцэтгэх захирал



/Х.Цэнгэлбаяр/

## ГАРЧИГ

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	2
1.1 Төслийн нэр .....	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг .....	2
1.3 Төслийн байршил .....	2
1.4 Төслийн хүчин чадал, барилга байгууламж .....	3
<b>ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	6
2.1. Цаг уур, уур амьсгалын онцлог .....	7
2.1.3 Салхины горим .....	7
2.2 Агаар бохирдуулагч түгээмэл тархалттай бодисуудын тодорхойлолт .....	8
2.2.1. Агаарын чанарын хэмжилт, шинжилгээний аргачлал .....	10
2.2.2. Агаарын чанарын хэмжилт, судалгааны үр дүн .....	10
2.3. Хөрсөн бүрхэвч .....	11
2.4. Ургамлын аймаг .....	13
2.5. Гадаргын болон газар доорх усны нөөц, онцлог, чанар .....	14
2.5.1. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц .....	14
2.5.2 Гадаргын ус .....	15
2.5. Газрын доорх ус .....	15
2.6. Амьтны аймаг .....	16
2.7. Нийгэм эдийн засаг .....	17
<b>ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	20
<b>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ</b> .....	22
<b>ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	23
<b>ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	25
<b>ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	26
<b>НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	27
<b>ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	28
<b>АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b> .....	29
<b>АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	30
<b>АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	31
<b>АРВАН ГУРАВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ</b> .....	32

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ-2023)

### 1.2 Төслийн зорилго:

Ачилт буулгалтын үйл ажиллагаа явуулан иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбайн төслийг хэрэгжүүлж байна.

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг

“Батганжир” ХХК

Улсын бүртгэлтийн дугаар: 9011282106


Регистрийн дугаар: 5471079

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мөрү Тауэр, 701 тоот

Утас: 77111071

### 1.3 Төслийн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км зайд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах төмөр замын баруун талд, Эрчим хүч ус хангамжийн 2-р дугаар ангийн Чойр салбарын баруун хойд талд байрладаг.



Зураг 1. Төслийн талбайн байршил

**Хүснэгт 1.Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбайн координат**

№	X	Y
1	5138747.57	296631.87
2	5138725.41	296729.38
3	5138515.12	296703.02
4	5138457.20	296695.75
5	5138466.23	296623.75
6	5138552.14	296634.52
7	5138566.13	296608.63
8	5138729.21	296629.07

**1.4 Төслийн хүчин чадал, барилга байгууламж**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбайн төсөл нь одоогоор нүүрс буулгах хяналтын талбай 2.5 га газарт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус хяналтын талбай нь ажилчдын байр, 150 тн-ийн 2 ш пүү, засварын цех, харуулын байр, гал тогоо, оффис гэсэн хэсгүүдээс бүрдэж байна.



**Зураг 2. Ажилчдын байр, цайны газар, оффис**



**Зураг 3.Засварын хэсэг**



**Зураг 4.Талбайн машины граш**





**Зураг 5.Харуулын байр**



**Зураг 6. Нүүрс хадгалах талбай**

Төмөр замын салбар замын ачилт буулгалтын талбарт вагон тавьж өгөх, татаж авах, сэлгээний ажил гүйцэтгэх төслийн салбар замын бүрэн урт нь 335м, ашигтай урт нь 328 м, суман шилжүүлэг, гарамгүй.



**Зураг 7. Воган явах зам**

Салбар замын уртаас хамааран нэг удаа нэгэн зэрэг тавьж өгч, ачиж буулгах вагоны тоог зам тус бүр дээр дараах байдлаар тогтоогдсон байдаг. Үүнд Ачилтын фронт:

- ❖ Ачаа буулгахад 20 вагон
- ❖ Ачаа ачихад 20 вагон
- ❖ Нэгэн зэрэг 10 вагон ачиж, 10 вагон буулгана.

Дэд бүтцийн хувьд ачилт буулгалтын талбай нь Сүмбэр сумын төвийн эрчим хүчний системд холбогдсон. Гадна талбайн гэрэлтүүлэг MNS 6426:2013 стандартын 5.4.3-т заасны дагуу нарны зайгаар ажилладаг, хөдөлгөөн мэдрэгчтэй.

**Уур, дулаан, нүүрсний хэрэглээ:** Ачиж буулгах талбай баригдсан барилга байгууламжуудын халаалтыг БНХАУ-д сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэгдсэн нүүрс бага хэрэглэдэг, өндөр хүчин чадалтай уурын зуух ашиглаж байна. Тус уурын зуух нь хоногт 10.0 тн нүүрс түлдэг.

“Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Монгол Улсын Засгийн газрын 62-р тогтоол болон Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 тоот захирамжийг дагуу MNS 6457:200014 стандартын шаардлага хангасан нүүрсийг ашиглах хэрэгтэй.



**Зураг 8. Уурын зуух**

**Ус хангамж:** Ажилчдын унд ахуйн зориулалтаар ус хэрэглэдэг ба төслийн талбайд 1 ширхэг гүний худаг гарган ашиглаж байна.

Унд ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний худаг нь 120 метрийн гүнээс татсан 2.0 л/сек ундаргатай.

**Хүснэгт 2. Гүний худгийн мэдээлэл**

№	Солбицол		Ундарга	Цооногийн гүн	Зориулалт
	X	Y			
1	5138515.12	296703.02	2.0 л/сек	120.0 м	Унд-ахуй



Зураг 9. Унд-ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний худаг

### **Хог хаягдал**

Төслийн үйл ажиллагаанаас гол төлөв ахуйн хатуу, шингэн хаягдал гардаг. Хатуу хаягдал хоногт 0.012 тн, шингэн хаягдал хоногт 1.2 м<sup>3</sup> орчим үүсдэг.

Ахуйн хатуу хаягдлыг хашаанд байрлах 4 ширхэг саванд хатуу хаягдлын цэгт хуримтлуулж, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ”-ний дагуу төвлөрсөн хаягдлын цэг рүү ачуулан талбайгаас зайлуулж байна. Харин ахуйн шингэн хаягдлыг 20.0 м<sup>3</sup>-ийн багтаамжтай доторлогоотой бохирын цооногт хуримтлуулж бохир соруулах гэрээний дагуу соруулан зайлуулдаг.


## ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Цаг уур, уур амьсгалын онцлог

**2.1.1 Агаарын температур:** Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум нь халуун зунтай хуурай уур амьсгалын мужид хамаарна. Энд зуны идэвхтэй температурын нийлбэр 3000оС-аас их, чийг дулааны коэффициент 0.1-0.3 байдаг. Говьсүмбэр аймаг орчмоор салхины жилийн дундаж хурд 3.2 м/с байна. Жилийн дундаж харьцангуй чийгшил 65%, хөрсний гадаргын жилийн дундаж температур 2.40С байна. Эх газрын эрс тэс уур амьсгалтай ба олон жилийн сарын дундаж температураар 7-р сард хамгийн дулаан +30.4, +35.9 хэм, 1-р сард хамгийн хүйтэн -24, -34 хэмд хүрдэг байна. Хамгийн хүчтэй салхи шуурга 3-р сарын сүүлчээс 4-р сард ихэвчлэн хойд болон баруун хойноос шуурдаг бөгөөд 4-р сард салхины дундаж хурд 5.5 м/сек байдаг. Жилийн дундаж хур тунадас зуны улиралд 150-200 мм ба нийт тунадасны 75% нь 7-9-р саруудад буудаг. Өвлийн улиралд 75-125мм 10-р сарын дунд үеэс 2-р сар хүртэл алаг цоог цасан бүрхүүлтэй газрын хөрс 1.2 м хүртэл хөлдөнө.

**2.1.2 Хур тунадас:**Манай орны уур амьсгалын нөхцөлийг бүрдүүлэгч үндсэн үзүүлэлтийн нэг нь агаар мандлын хур тунадас билээ. Жил жилд орох хур тунадасны хэмжээ нилээд хэлбэлзлэлтэй байдаг.


Чойр цаг уурын станцын сүүлийн 20 жилийн хур тунадасны мэдээгээр жилд орох хур тунадасны дундаж хэмжээ 147.8 мм, хамгийн их тунадас орсон жил 2003 онд 259.5 мм, хамгийн багадаа 2012 онд 71.3 мм байжээ (Зураг 10).



Зураг 10. Жилийн нийлбэр хур тунадасны явц (2000-2019 он)

### 2.1.3 Салхины горим

Газрын гадрага орчмын салхины горим нь орон нутгийн уул зүйн онцлог, агаар мандлын орчил урсгалаас хамаарч байдаг. Чойр орчмоор манай орны салхины ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд хойд, баруун хойд чиглэлийн салхи зонхилдог. Тухайлбал хойд чиглэлийн салхи нийт салхины чиглэлийн 40% хүртэл, баруун хойдоос 18%, өмнөдөөс 14%, бусад чиглэлийн салхи 4-8%-ийн давтагдалтай байдаг байна (Зураг 11). Салхины чиглэл улирлаас хамаарч өөрчлөгдөж байх боловч ерөнхий зүй горим хадгалагдана.



Зураг 11. Салхины зонхилох чиглэл, хувиар

## 2.2 Агаар бохирдуулагч түгээмэл тархалттай бодисуудын тодорхойлолт

Хот суурин газрын агаарын чанарын хяналт шинжилгээнд ихэвчлэн түлшний шаталтаас үүдэлтэй зарим бохирдуулагч бодисуудыг сонгон тодорхойлдог. Эдгээрээс хамгийн түгээмэл илэрцтэй бохирдуулагч бодисууд нь тоос тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл юм.

**Хүхэрлэг хий SO<sub>2</sub>** - Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий. Нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан бүх төрлийн түлшний шаталт, металл боловсруулах үйл ажиллагааны дүнд үүсдэг. Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдэх нь олон талын сөрөг нөлөөлөлтэй ба өндөр агууламжтай үед гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар исэл нь амьсгал цочроосноос найтаах, ханиах зэрэг физиологийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээдэг. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг. Мөн хүчиллэг тунадас (H<sub>2</sub>SO<sub>4</sub>) үүсгэх зэргээр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, дэд бүтэц зэрэг бүхий л салбарт сөргөөр нөлөөлдөг.

**Азотын давхар исэл NO<sub>2</sub>** –Азотын давхар исэл нь азот агуулсан түлшний шаталт болон өндөр температурт шаталтын бүтээгдэхүүн бөгөөд ихэвчлэн шаталтын үеийн дулаан шингээх урвалын үр дүнд үүсдэг өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.


**Тоосонцор (PM<sub>1.0</sub>, PM<sub>2.5</sub>, PM<sub>4.0</sub>, PM<sub>10</sub>, нийт тоос TSP)** - Агаарын чанарын судалгаанд тоос тоосонцор гэдэг нь маш өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүсэж буй

эх үүсвэр, агаар мандал дахь физик химийн урвалаас хамаараад маш жижиг буюу нано хэмжээнээс эхлээд хэдэн арван микрометр хүртэлх ширхэглэгийн хэмжээтэйгээр илэрдэг (Зураг 12).



**Зураг 12. Агаар мандал дахь тоосонцруудын харьцангуй агууламж**

Байгалийн эрдэс минералууд болон биологийн гаралтай тоос тоосонцор харьцангуй том ширхэглэгийн хэмжээтэйгээр агаар мандалд илэрдэг бол бүх төрлийн түлшний шаталтаас үүдэлтэй тоосонцор нь хэмжээний хувьд маш жижиг байхаас гадна хортой химийн элементүүдийг агуулж байдаг. 10 микроноос том ширхэгтэй тоос тоосонцор нь хамар ам, мөгөөрсөн хоолойд баригдаж гадагшилдаг бол 10 микроноос бага диаметртэй тоос /PM10/-ны ширхгүүд нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2.5-10 микрометр бүхий тоосны ширхгүүд нь уушгины мөгөөрсөн хоолой болон хялгасан судлуудад хуримтлагдах, харин 2.5 микроноос бага диаметртэй ширхгүүд нь уушгины цулцангуудад шигдэх аюултай байдаг (Зураг 13).



**Зураг 83. Агаар дахь тоосонцорын ширхгийн хэмжээнээсээ хамааран хүний амьсгалын эрхтэнүүдээр шүүгдэж хуримтлагдах хэмжээ**

Тоос үүсгэгч эгэл хэсгүүд нь аэродинамикийн хэмжээ, тунах (хүнд хүчний уналтын) хурд, агаар мандлын турбулент хөдөлгөөнөөс хамааран эх үүсвэрээс янз бүрийн зайд тархаж бохирдуулдаг.

### 2.2.1. Агаарын чанарын хэмжилт, шинжилгээний аргачлал

**Хүхэрлэг хий.** Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозанадины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлдог.

**Азотын давхар исэл.** Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаа 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанадины хүчилтэй харилцан үйлчилж diaзонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь  $\alpha$ -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.

**Тоос, тоосонцор.** Судалгаанд ашиглагдсан тоос хэмжигч багажууд нь АНУ-ын TSI корпорацийн бүтээгдэхүүн бөгөөд DustTrak 8520, DustTrak 8530 загваруудын хувьд агаар дахь тоос тоосонцрыг ширхэглэгийн хэмжээнээс нь хамааруулан сонгомол хэлбэрээр тодорхойлдог. Энэ төрлийн багаж нь агаар дахь нийт тоос, PM10, PM4.0, PM2.5, PM1.0 хэмжээтэй тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг тодорхойлох боломжтой юм. Уг багажийн ажиллах зарчим нь агаарын сорьцыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар соруулан оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн сарнил тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй агаар дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдагт үндэслэдэг.



Зураг 94. Агаарын чанарын хэмжилт хийсэн багаж, тоног төхөөрөмжүүд

### 2.2.2. Агаарын чанарын хэмжилт, судалгааны үр дүн

Төсөл хэрэгжих талбайн агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлох хэмжилт судалгааг 2022 оны 11-р сарын 11-ний өдөр хийж гүйцэтгэсэн бөгөөд хэмжилтийн үр дүнг Монгол улсад мөрдөгдөж буй гадаад орчны агаарын чанарын техникийн шаардлагын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулав.

Төслийн талбайн агаар дахь бохирдуулагч бодисуудын нэг удаагийн буюу 20 минутын дундаж хэмжилтийн үр дүнгээс үзэхэд хүхэрлэг хий болон азотын давхар ислийн

агууламж нь “Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016” -д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна. Харин нийт тоосны бага болон дундаж агууламж стандартын ЗДХ-ээс бага үзүүлэлттэй гарсан байна.

**Хүснэгт 3. Агаарын чанарын хэмжилт, шинжилгээний дүн**

№	Хэмжилт хийсэн цэг	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /	Азотын давхар исэл /NO <sub>2</sub> /	Нийт тоос/TSP/
1	АЧХЦ	11.00 цагт 0.015 12.00 цагт 0,019	11.00 цагт 0.023 12.00 цагт 0,027	0.025
<b>MNS 4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ /20 минутын дундаж хэмжилт/</b>		<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>


### 2.3. Хөрсөн бүрхэвч

“Төмөр замын ачилт буулгалтын талбай”-н хөрсөн бүрхэвч нь хөрс-газар зүйн мужлалаар говийн их мужид багтах бөгөөд цөлийн бор саарал хөрсний бүсийн заг сүүж-борзонгийн говийн тойрогт хамаарна. Тухайн бүс нутгийн ургамлан бүрхэвч нэн сийрэг учраас ус, салхинд хөрс эвдэрч элэгдэх үзэгдэл нэн түгээмэл. Түүнээс гадна уулын бэл хормой, уулсын хоорондох хотгор, хуурай сайруудаар нэл хэрчигдсэн байдаг. Өөр нэг өвөрмөц онцлог нь газрын өнгөн хэсэг он удаан жилийн турш ус, салхины үлээгдэлд нэрвэгдэж нунтаг шороо нь элж нимгэрсээр хөрсний гадарга дээр бүрхмэл хуяг мэт сайр чулуун хучаас тогтсон байдаг. Дээрх говийн онцлог уур амьсгал, байгалийн нөхцөл, гадаргын хэлбэрээс шалтгаалан тус лицензийн талбайд дараах хэдэн төрлийн хөрсний хэв шинжүүд тод ялгаран тархсан байдаг.

- ❖ Сайргархаг бор
- ❖ Сайргархаг цайвар бор
- ❖ Сайргархаг бор саарал
- ❖ Сайргархаг нимгэн бор саарал
- ❖ Чулуун хучаастай цайвар бор
- ❖ Карбонаттай бор саарал
- ❖ Сайрын элсэрхэг ба чулуурхаг
- ❖ Шалархуу
- ❖ Авто замын эвдэрсэн хөрс
- ❖ Хайрга чулууны карьер



**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай"-н 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



**Зураг 15.Төслийн талбайн хөрсөн бүрхэвч**

**Хүснэгт 4. Хөрсний химийн үндсэн шинж**

№	Дээжний нэр	Гүн см	рН	ЦДЧ.dsm	Давс	Ялзмаг %	CaCO <sub>2</sub> %	Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								P2O5	K2O
1	2	3	4	5	6	7	9	13	14
09/1721	Дээж-3	-	8.8	0.916	0.42	1.57	1.48	2.5	36

**Хүснэгт 5. Хөрсний механик бүрэлдэхүүн**

№	Дээжний нэр	Гүн.см	Механик ширхэгүүд. % ширхэгийн хэмжээ, мм						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
09/1721	Дээж-3	-	32.3	40.6	13.3	3.5	9.2	1.1	13.8

**Хүснэгт 6. Хөрсний хүнд металлын агууламж**

№	Дээжний нэр	Гүн.см	Хүнд металл мг/кг					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс /	Zn /Цайр /	Cr /Хром /
09/1722	Дээж-1	-	36.4	ND	25.6	11.5	71.6	10.7
Хүлцэх агууламж / MNS 5850:2019/			150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж /MNS:2019 /			1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/			1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0

## 2.4. Ургамлын аймаг


Уг төслийн талбайн газрын гадарга, ладшафтын хувьд тэгшивтэр тал хөндийн хэв шинж илэрч байна. Төслийн талбайн орчны ургамлын аймгийн хувьд хуурай хээрийн ургамал зонхилон тохиолдох бөгөөд хуурай хээр, цөлөрхөг хээрийн завсрын бүсэд байрлаж байна. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэцийн хувьд харьцангуй тачир сийрэг ургамалтай ба өвслөг ургамлаас дараах зүйл ургамлууд судалгааны явцад бүртгэгдсэн. Үүнд:

- ❖ Сайрын хялгана / *Stipa glareosa* /
- ❖ Говийн хялгана / *Stipa gobical* /
- ❖ Зүүн гарын хазаар өвс / *Cleistogenes soongariaca* /
- ❖ Таана / *Allium polyrhizum* /

Сөөгөнцөр, хагас сөөгөнцөр ургамлаас:

- ❖ Түжгэр баглуур / *Anabasis brevifolia* /
- ❖ Шүлхий шарилж / *Artemesia pectinate* /
- ❖ Элсний түмэн таана / *Chamaerhados sabulsa* /
- ❖ Толгодын бударгана / *Salsola collina* /

Ургамалжилтын зүйлийн хувьд 17 овгийн 37 төрлийн нийт 41 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд мод-1, Сөөглөг-7, Сөөгөнцөр-4, Сөөгөнцөрлөг- 4, олон наст өвс- 17, хоёр наст- 1, нэг наст- 7 зүйл ургамалтай.




Зураг 16. Төслийн талбайн ургамалан нөмрөг

## 2.5. Гадаргын болон газар доорх усны нөөц, онцлог, чанар

### 2.5.1. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц

Төслийн талбай байрлах нутаг дэвсгэр нь Монгол улсын гидрогеологийн бүсчилээр зүүн Монгол гидрогеологийн бүсийн говийн мужийн хойт хэсэгт байрлана. Энэ мужид ихэвчлэн уулс хоорондын геологийн бүтцүүдэд хөрсний ус тархсан байдаг. Тухайн орчинд тархсан газрын доорх ус нь хөдөлгөөн ба хуримтлалын нөхцөлөөр ан цавын, нүх сүвийн гэсэн хоёр төрөлд хуваагдана. Ан цавын ус нь ихэвчлэн Чойрын хотгорыг хүрээлэн тогтсон палеозей-мезозойн боржин, доод цэрдийн бялхмал чулуулгийн ан цавд, нүх сүвийн ус нь хотгорыг дүүргэсэн цэрд, дөрөвдөгчийн хурдсанд тархжээ. Мөн гидравлик шинж чанараар нь чөлөөт гадаргуутай ба түрэлттэй гэж хуваана. Чөлөөт гадаргуутай ус нь хотгорын захын гүний болон бялхмал чулуулгууд, дээд ба орчин үеийн дөрөвдөгчийн пролюви, аллювийн хурдсанд хааяа хотгорын төвийн доод цэрдийн хурдсанд, түрэлттэй ус нь Чойрын хотгорыг дүүргэсэн доод цэрдийн хурдсанд тархжээ. Түрэлт нь уст үе давхаргууд зузаан, ус үл нэвтрүүлэгч шаврын доор байрласнаас, мөн тэдгээртэй үелэн тогтсоноос үүсдэг байна. Чойрын хотгорт газрын доорх усны тэжээгдэл, зөөгдөл, хуримтлалын мужууд тодорхой ялгагддаг. Тэжээгдэл, зөөгдлийн муж нь палеозой, хааяа мезозойн хурдсаас тогтсон хотгорын захын өргөгдсөн хэсгүүдийг багтаана. Хуримтлалын муж нь мезозой, палеозойн тунамал, сэвсгэр хурдаснаас бүрдсэн Чойрын хотгорыг эзлэн оршиж байна. Жил бүр хур тунадасны нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсацын нөлөөгөөр дахин бүрэлдэх боломжтой усны хэмжээг газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц гэнэ. Нөхөн сэргээгддэг нөөц нь тухайн нутгийн агаарын хур тунадас, уур амьсгал, гол, горхийн нөлөө, хөрс чулуулгийн онцлогоос хамаарч газрын доорх усанд орж буй усны тэжээгдлийн хэмжээг илэрхийлдэг байнгын бус хэмжигдэхүүн бөгөөд нөөц хуримтлагдах геологи-гидрогеологийн таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд ашиглах боломжтой байдаг.

Энэхүү төслийн талбайн газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөцийн тархалтын зургаас харахад газрын доорх урсацын түвшин жилд 5 мм-ээс бага буюу маш бага нөөцтэй хэсэгт хамаарч байна.



Зураг 1710. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц

## 2.5.2 Гадаргын ус

Төслийн талбай нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших бөгөөд гидрогеологийн мужлалын хувьд улирлын хомс тэжээлтэй мужийн Дорноговийн дэд мужид хамрагдана. Энэ бүс нутаг гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага байна. Гуу жалга, сайрууд цас их унасан жил хаврын улиралд шар усны үертэй, харин зуны улиралд хур бороо болон эрчимтэй их аадар борооны усаар тэжээгдэн түр урсгалтай болох ба үерлэнэ. Жилийн бусад хугацаанд сайр, гуу жалга, судаг урсацгүй байна. Хур бороо ихтэй услаг жилд ялангуяа эрчимшил ихтэй хур борооны үерийн үед сайраар үүсэх түр урсац шал тойром, хонхор газрыг ус, намагтай болгоно. Жилд унах хур тунадасны хэмжээ нь олон жилийн дунджаар 94.1 мм байа.

## 2.5.Газрын доорх ус

Говийн бүс нутгийн газрын доорх уст давхаргуудыг ундаргаар нь гурав ангилсан.

Үүнд:

- ❖ Бага талбайд тархсан, өндөр ундаргатай уст давхарга
- ❖ Багаас дундаж ундаргатай уст давхарга
- ❖ Хязгаарлагдмал бага нөөцтэй устай эсвэл газрын доорх усгүй хурдас чулуулаг болно.

Говийн бүсийн газрын доорх уст давхаргууд нь хур тунадасны усны нэвчилтээр тэжээл аван дээр орших бага гүний уст давхаргыг тэжээн, ургамлыг тэжээн, булаг, хуурай саарь, түр зуурын нөөц ус, эсвэл бага гүний худгаар газрын гадаргад илэрдэг. Бага хэмжээний ус гүний уст давхаргыг тэжээдэг ч хэмжээ нь мэдэгдэхгүй.

Ажилчдын унд ахуйн ус хэрэглээг хангаж буй гүний худгаас дээж авч Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид шинжлүүлэв. Усны шинжилгээг 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хийлгэсэн. Усны химийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд гүний худгийн ус нь газрын доорх усны чанарын шаардлагыг хангаж байна. Шинжилгээний үр дүнг хавсаргав.

### Хүснэгт 7. Усны химийн шинжилгээний үр дүн

№	Үзүүлэлт /Parameters/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үр дүн /Test result/
			Худаг (Унд ахуй)
1	Аммони, (NH <sub>4</sub> <sup>+</sup> ) мг/л /Ammonia ion, mg/l/	<1.5	0.01
2	Кальци, (Ca <sup>2+</sup> ) мг/л /Calcium ion, mg/L/	<100.0	61.52
3	Магни (Mg <sup>2+</sup> ), мг/л /Magnesium ion, mg/L/	<30.0	48.11
4	Нитрат(NO <sub>3</sub> <sup>-</sup> ), мг/л /Nitrate ion mg/L/	<50.0	26.62
5	Нитрит(NO <sub>2</sub> <sup>-</sup> ), мг/л /Nitrite ion mg/L/	<1.0	0.14
6	pH-Усан орчин /Hydrogen ions/	6.5-8.5	7.84
7	Сульфат (SO <sub>4</sub> <sup>2-</sup> ), мг/л /Sulfate ion, mg/L/	<500.0	156.58
8	Ерөнхий хатуулаг, мг-экв/л /Total hardness, mg-eq/l/	<7.0	7.03

9	Хлорид (Cl <sup>-</sup> ), мг/л /Chloride ion, mg/L/	<350.0	162.02
10	Хуурай үлдэгдэл, мг/л /TDS, mg/L/	<1000.0	998.0
11	Цахилгаан дамжуулах чанар, мСм/см /Electrical conductivity/	<1.0	1.8

## 2.6. Амьтны аймаг

Төслийн талбай нь тал хээрийн шинжийг илтгэх бөгөөд тус нутаг нь амьтны аймгийн мужлалаар Хээр, цөлөрхөг хээрийн мужийн Монгол дагуурын тойрогт хамаарагдана. Энэ тойргийн хувьд хээрийн зөвхөн энэ бүсэд дасан зохицсон амьтад ихэнх байр суурийг эзлэн оршдогоороо бусад биотопоос ялгардаг онцлогтой. Үүнд: үлийн цагаан оготно, шар чичүүл, дагуур зурам, дагуурын огдой, туурайтнаас цагаан зээр, махчдаас өмхий хүрэн, хярс, үнэг зэрэг зүйлүүд зонхилно.

**Шавж:** Тус нутгийн шавжийг тусгайлан судалж байгаагүй бөгөөд Монгол-Оросын хамтарсан биологийн экспедицийн шавж судлалын отряд тус нутгаар аялал, судалгаа хийх явцдаа 8 багийн 106 зүйл шавж тэмдэглэсэн байна.

**Хоёр нутагтан, мөлхөгчид:** Судалгааны талбай болон түүний ойр орчимд хоёр нутагтан амьтад илрээгүй. Харин мөлхөгчдийн багийн амьтдаас хонин гүрвэл элбэг тохиолдоно.

**Шувуу:** Энэ нутагт тал хээрийн шувууд голлон амьдарна. Мөн дан ганц тал хээр тохиолддог шувуудаас гадна ус намгархаг газрын шувууд болон хот суурин газарт дайралддаг шувууд түгээмэл ажиглагддаг байна. Нутгийн иргэдээс авсан мэдээллээр сохор элээ, өвөөлж, улаан хошуут жунгаа, хөх хэрээ, монгол болжмор, хээрийн бор шувуу, өвөгт тогоруу, нарийн хиазат, мөнгөлөг цахлай зэрэг шувуу судалгааны талбайн ойр орчимд тохиолддог байна.

**Хөхтөн:** Монгол-Оросын судлаачдын хамтран хийсэн хөхтөн амьтдын судалгаанаас үзэхэд төсөл хэрэгжих бүс нутагт 14 зүйл хөхтөн амьтныг тэмдэглэсэн байна. Харин Монголын үндэсний атласт 10 зүйлийг тэмдэглэсэн байдаг. Эдгээрээс дурьдвал боролдой туулай, цайвар үлий, шивэр алагдаага, шар үнэг, хярс үнэг, цагаан зээр, дэлдэн зараа зэрэг амьтад тохиолддог байна.

Төслийн талбай нь Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн төмөр зам дагуу хүн ам төвлөрсөн суурин газарт орших тул томоохон хөхтөн амьтад байнга байршин амьдрах боломжгүй юм.

## 2.7. Нийгэм эдийн засаг

Засаг захиргаа, нутаг дэвсгэр: БНМАУ-ын Бага хурлын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулжээ. Говьсүмбэр аймаг нь Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд оршдог, 5.5 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, Төв, Хэнтий, Дорноговь, Дундговь аймгийн сумтай хил залган байрладаг.

**Хүн ам:** 2021 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймгийн нийт хүн ам 18150 байсан ба үүнээс эрэгтэй 9196, эмэгтэй 8954 байна. Өмнөх онтой харьцуулбал хүн ам 44 буюу 0.4 хувиар өссөн байна. Нийт хүн амын 50.4 хувийг эрэгтэйчүүд, 49.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны ангиллаар авч үзвэл нийт хүн амын 34.4 хувийг 0-14 насны хүүхэд, 59.2 хувийг 15- 59 насны хүмүүс, 6.3 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 398, 80 ба түүнээс дээш настан 121, 90 ба түүнээс дээш настан 17 тоологджээ. Дээрх үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 70 ба түүнээс дээш настан 1.5 хувиар, 80 ба түүнээс дээш настан 0.8 хувиар, 90 ба түүнээс дээш настан 11.8 хувиар өссөн байна.

Тус онд 5261 өрх тоологдсон нь өмнөх оноос 200 өрхөөр ихэссэн үзүүлэлттэй байна. Нийт өрхийн 3083 буюу 58.6 хувь нь хотод, 2178 буюу 41.3 хувь нь хөдөөд байршиж байгаа бол нийт өрхийн 2051 буюу 38.9 хувь нь гэрт, 3115 буюу 59.2 хувь нь байшинд, 95 буюу 1.9 хувь нь бусад сууцанд амьдарч байна.

**Боловсрол:** 2021-2022 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 44 цэцэрлэгийн 54 бүлэгт 1725 хүүхэд хамрагдаж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 205 буюу 11.9 хувь нь малчдын хүүхэд байна. Ерөнхий боловсролын сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилд 5 сургуулийн 136 бүлэгт 3797 сурагч суралцаж байгаагаас I-V ангийн 65 бүлэгт 2021 сурагч, VI-IX ангийн 46 бүлэгт 1213, X-XII ангийн 25 бүлэгт 563 сурагч суралцаж байна. Дотуур байранд 142 сурагч амьдарч байна. Өмнөх онтой харьцуулбал бүлгийн тоо 2.4 хувиар, суралцагсад 6.2 хувиар, дотуур байранд амьдарч буй сурагч 7.6 хувиар тус тус өссөн байна. Мөн 2019 оны байдлаар Говьсүмбэр аймгийн МСҮТ-д нийт 15 мэргэжлээр 693 суралцагч суралцаж байна. Аймгийн хэмжээний сургууль цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд судалгаанд 62 хүүхэд хамрагдсанаас цэцэрлэг, сургуульд 48 сурагч, сургууль цэцэрлэгт хамрагдах боломжгүй 14 хүүхэдэд гэрээр хичээл зааж байна.

**Эрүүл мэнд:** Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2021 онд 427 эх амаржиж, энэ нь 2020 онтой харьцуулахад 44 буюу 9.3 хувиар буурсан байна. 2021 оны байдлаар 97.1 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оноос 11.7 хувиар, 4.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оноос 6.0 хувиар тус тус буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгсөд 166 бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 тохиолдлоор буурчээ.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн:** 2021 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 15456.6 сая төгрөг, гүйцэтгэл 16528.1 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 106.9 хувийн биелэлттэй байна. Төсвийн орлогыг задаргаагаар нь авч үзвэл урсгал орлого 19.7 хувиар даван биелсэн үзүүлэлттэй байна. Төсвийн зарлага 15437.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 16528.1 сая төгрөг буюу 107.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт зардлыг задаргаагаар нь авч үзвэл урсгал зардал 9.7 хувийн хэтрэлтэй гарчээ. Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр өглөгийн үлдэгдэл 255.5 сая төгрөг, авлагын

үлдэгдэл 51.5 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс өглөг 3.8 дахин, авлага 1.8 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Мал аж ахуй:** 2021 оны жилийн эцсээр Говьсүмбэр аймаг 452.0 мянган толгой малтай болсон нь өмнөх оны мөн үеэс 24.5 мянган толгой буюу 5.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 22.7 мянган толгой, үхэр 14.5 мянган толгой, тэмээ 0.9 мянган толгой, хонь 219.5 мянган толгой, ямаа 194.2 мянган толгой тус тус тоологджээ. Аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 84.3 хувь буюу 171.5 мянган толгой мал төллөж, гарсан төл 172.0 мянга, үүнээс 5.4 мянган толгой төл хорогдож, 166.9 мянган толгой төл бойжиж, төл бойжилт 91.5 хувьтай гарсан байна. 2018 онд 33.9 мянган толгой төл хорогдсон бол 2019 онд 5.4 мянган толгой төл хорогдож өмнөх оны мөн үеэс 28.5 мянга буюу 662 дахин буурсан байна. Жилийн эцсийн байдлаар 5.7 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 33.9 мянга буюу 6.9 дахин буурсан байна. 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 1022 малтай өрх тоологдсоноос 699 малчин өрх, 323 малтай өрх тоологджээ. Малчин өрхөд 2347 хүн амьдарч байгаагаас 1097 малчин, үүнээс 481 нь эмэгтэй малчид байна.

**Газар тариалан:** 2019 онд 49.7 га талбайд тариалалт хийснээс төмс 17.9 га-д, хүнсний ногоо 18.8 га-д, тэжээлийн ургамал 13.0 га-д тариалсан байна. Өмнөх онтой харьцуулбал нийт тариалсан талбай 9.5 га буюу 23.6 хувиар өссөн ба төмсний талбай 2.7 га буюу 17.8 хувиар, хүнсний ногооны талбай 5.8 га буюу 44.6 хувиар, тэжээлийн ургамлын талбай 1 га буюу 8.3 хувиар тус тус нэмэгдсэн байна. 2019 онд 2125.4 тонн өвс, 1.01 тонн дарш, 507.7 тонн хужир шүү бэлтгэж авсныг өмнөх онтой харьцуулбал бэлтгэсэн өвс 51.6 хувиар, хужир шүү 14.8 хувиар, дарш бэлтгэлт 66.3 хувиар буурсан байна.


### **Сүмбэр сумын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал**

Түүхэн замнал: БНМАУ-ын Бага хурлын 1931 оны 02 дугаар сарын 07- ны өдрийн 05 дугаар хуралдааны тогтоолоор хошуудыг татан буулгаж, Засаг захиргааны нэгжийг өөрчлөн 13 аймаг байгуулж өргөжүүлэхэд Оцол Сансар уулын хошууг Төв, Дорноговь аймгийн харьяанд хуваасан байна. Ийнхүү 1931 онд Сансар, Баянбулаг, Их хонгор, Баян-Эрхтий сумуудыг нэгтгэж, Төв аймгийн Говьсүмбэр одоогийн Сүмбэр сумыг байгуулсан байна.

**Нутаг дэвсгэр:** Сумын нутаг дэвсгэр нь далайн түвшнээс дээш 1269 м өндөрт өргөгдөн оршдог. Жаргалант, Сэлэнгэ, Орхон Баянгол гэсэн сумтай тус тус хиллэдэг. 3,768.2 км<sup>2</sup> газар нутагтай. Засаг захиргааны хувьд нийт 4 багтай. Сумын газар нутгийг газрын нэгдмэл сангийн ангилалаар ангилвал хөдөө аж ахуйн зориулалттай газар 2180.63 км<sup>2</sup>, ойн сан бүхий газар 1189.54 км<sup>2</sup>, усан сан бүхий газар 383.35 км<sup>2</sup>-ыг тус тус эзлэх байгаа бөгөөд төслийн талбай нь газрын нэгдмэл сангийн ангилалаар хөдөө аж ахуйн эдэлбэр газарт хамаарна.

**Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** 2021 оны жилийн эцсийн байдлаар Сүмбэр суманд 3821 өрхийн нийт 18153 хүн оршин сууж байгаагаас 9047 эрэгтэй, 9106 эмэгтэй бөгөөд өмнөх онтой харьцуулахад өссөн байна. Үүнээс I багт 830 өрхийн 2861 хүн, II багт 1010 өрхийн 3351 хүн, III багт 1241 өрхийн 4619 хүн, IV багт 259 өрхийн 827 хүн, V багт 240 өрхийн 745 хүн VI багт 239 өрхийн 749 хүн оршин сууж байна.

Сумын иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 0-14 насны иргэд 4345, 15-19 насны иргэд 871, 20-29 насны иргэд 2007, 30-39 насны иргэд 1957, 40-49 насны иргэд 1550, 50-59 насны иргэд 1158, 60-с дээш насны иргэд 752 байна. Сүмбэр суманд хөдөлмөрийн насны 4059 хүн бүртгэгдсэн байна.



**Зураг 118. Сумын иргэдийн насны бүлгийн ангилал**

**Боловсрол:** Төрийн өмчит сургуулийн өмнөх боловсролын байгууллага 4 байх ба нийт 170 багш ажилтантай, 2021-2022 оны хичээлийн жилд нийт 1677 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. Төрийн бус боловсролын байгууллага 4, нийт 203 хүүхэд 21 багш ажилчинтай үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий боловсролын дунд сургууль тус суманд 3 байгаагаас 1-р арван жилийн сургуульд нийт 1130 сурагч, 87 багш ажилчид, 2-р арван жилийн сургуульд 780 сурагч 66 багш ажилчид, 5-р арван жилийн сургуульд нийт 1248 сурагч, 80 багш ажилчид тус тус ажиллаж байна.

**Мал аж ахуй:** Сүмбэр сумын нийт малын тоо толгой 2019 оны жилийн эцсийн байдлаар 325928-д хүрч өмнөх оноос 5.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 681 тэмээ, 15576 адуу, 9898 үхэр, 157094 хонь, 142679 ямаа байна. Малтай өрх 723, малчин өрх 525 болж өмнөх оноос 1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мал бүхий өрх 198 болж өмнөх оноос 2.5 хувиар тус тус өссөн байна. Нийт малчдын тоо 2019 онд 837 бүртгэгдсэн бөгөөд 370 эмэгтэй, 460 эрэгтэй. Нийт малчдыг насны ангиллаар нь авч үзвэл 15-34 насны 202, 35-54 насны 507, 60 ба түүнээс дээш насны 128 малчин байна.

**Газар тариалан:** 2019 онд 14.9 га талбайд төмс, 13.8 га талбайд хүнсний ногоо, 10 га талбайд тэжээлийн ургамал тарилсан байна. Харин үр тариа тариалаагүй байна. Сүмбэр сумын ургац хураалтын байдлыг авч үзвэл 2019 онд 108.8 тн төмс хурааж өмнөх оноос 67.1 хувиар өссөн бол 110.6 тн хүнсний ногоо хурааж өмнөх оноос 74.2 хувиар өссөн, 50 тн тэжээлийн ургамал хурааж өмнөх оноос 25 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Цахилгаан хангамж:** Сум нь төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон.

**Дулаан хангамж:** Сумын төвд 5 бага оврын уурын зуух, 1 цахилгаан халаагуураар дулааны хэрэгцээгээ хангаж байна.

**Ариутгах татуурга:** САА-н үед ашиглаж байсан байгууламж эвдэрч 1989 оноос хойш ашиглагдаагүй. Одоогоор цэвэрлэх байгууламж байхгүй байна.



**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ  
ТОДОРХОЙЛОЛТ**

**Хүснэгт 8. Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим**

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>								
Газрын доорх урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x			x			x
Гадаргын усны урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x			x			x
Геологийн тогтоцын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>								
Газрын гадаргын нөөц баялаг	x				x			x
Бэлчээрийн байдал		x			x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	Нөлөөлөл байхгүй							
Эрчим хүчний нөөц	x				x		x	
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>								
Ундны усны чанар, хэмжээ		x			x		x	
Хөрсний бохирдол	x				x		x	
Агаарын бохирдол		x			x			x
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x			x		x	
Дуу чимээ, шуугианы нөлөө	Нөлөөлөл байхгүй							
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл</b>								
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x			x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x			x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй							
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй							
<b>5. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө</b>								
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		x			x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x		x	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх		x			x		x	
Татварын орлого өөрчлөгдөх		x			x		x	
Нийгэм эдийн засгийг тогтвортой байлгах, шаардлагатай үед бараа материалаар хангах		x			x		x	
Ажлын байр нэмэгдэх		x			x		x	
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>12</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>19</b>	<b>0</b>	<b>13</b>	<b>6</b>

Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл. Нийт болзошгүй нөлөөллийн 7 (36.8%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн үйл ажиллагааны үед төслийн талбайн ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч, газрын гадаргын нөөц баялаг зэрэгт шууд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

Шууд бус нөлөөлөл. Нийт болзошгүй нөлөөллийн 12 (63.2%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Тухайлбал газрын доорх усны чанарын өөрчлөлт, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, бэлчээрийн байдал, ундны усны чанар хэмжээ, хорт бодис усаар дамжин хүн амьтанд нөлөөлөх зэрэг шууд бус сөрөг нөлөөллүүд гарч болзошгүй.

Нөлөөллийн хугацаа.Төслийн үйл ажиллагаа жил бүр тогтмол явагдах тул нөлөөллийн үргэлжлэх хугацааг урт хугацаанд хамруулсан болно.

Нөлөөллийн эрчим. Нийт нөлөөллийн 36.8 хувь нь дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, 31.6 хувь нь бага зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл байна. Харин орон нутгийн болон иргэдийн аж амьдрал, нийгэм эдийн засагт эерэг сайнаар нөлөөлөх ба энэ нь нийт нөлөөллийн 31.6 хувийг эзэлж байна.

Төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь нүүрс ачиж буулгах, зөөвөрлөх үед агаарт бий болох тоосжилт юм. Түүнчлэн газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын доорх усны чанарт багаас дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Тухайлбал машин механизм, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүний үйл ажиллагаагаар хөрсөн бүрхэвч элэгдэж эвдрэх, хатуу шингэн хаягдлаар бохирдох, хөрсний өнгөн хэсэг талхлагдан доройтох, байгалийн ургамлан нөмрөг устах, ургамлын ургалт саарч доройтох, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас шатахуун, тос тосолгооны материал асгарч хөрс болон газрын доорх усны чанарт сөргөөр нөлөөлөх, агаарт хийн төлөвт бохирдуулагч ялгарах, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрхөмжийн ашиглалттай холбоотойгоор дуу чимээ ихээр үүсч физик бохирдол бий болгох зэрэг сөрөг нөлөөлөл бий болж болзошгүй.

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, аргачлалын дагуу боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардал, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлэв.

2023 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 108,495,000 (нэг зуун найман сая дөрвөн зуун ерэн таван мянган) төгрөг төлөвлөлөө. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийх ажлын шууд зардлууд бөгөөд бусад урьдчилан тогтоох боломжгүй болон туслах чанарын ажлын зардлыг энд оруулаагүй болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь “Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн тайланг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.1-д заасны дагуу 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

**ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал / төг/	Тоо хэмжээ	Нийт зардал / төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт аргачлал
	2	3	4	5	6	7	8	9	10
1	Хог хаягдлын менежмент, төлөвлөлт, хариуцах эзэнгүй байдлаас хатуу хаягдлын хуримтлал бий болох, үүнээс улбаалж нян тархаж, халдварт өвчин гарах	Хог хаягдлын цэгийн цэвэрлэгээ, ариутгалын ажлыг тогтмол хийх	Ажлын байр, гадна талбай	тн	-	-	Төслийн өдөр тутмын үйл ажиллагааны зардалд орно	Тогтмол	Сумын ИТХ-ын 2018.12.19-ний 07 тогтоол
2	Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлөх	Тоосжилтыг бууруулах үүднээс төслийн талбайг хатуу хучилттай болгох	Төслийн талбай	М <sup>3</sup>	198,000	25.2	5,000,000	2023 оны 04 дүгээр сараас 09 дүгээр сар хүртэл	MNS 4912 : 2016
		Тоосжилтыг бууруулах зориулалтын хашаа барих	Төслийн талбай	М	1280	78,125	100,000,000	2023 оны 04 дүгээр сараас 09 дүгээр сар хүртэл	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
3	Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөнд хүнд металл их хэмжээгээр агуулагдсанаас хүний биед сөрөг нөлөө үзүүлэх.	Хөрсөн дахь химийн бодис болон хүнд металлын түвшинг тодорхойлж саармагжуулах арга хэмжээ авах	Төслийн хатуу хучилт хийгдээгүй талбайгаас	М <sup>2</sup>	100.000	1	100.000	2023 оны 7-р сард	MNS 5850 : 2008

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай"-н 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Хууль эрх зүйн орчны зөрчил бий болох	Гүний худгийг тоолууржуулах		ш	300,000	1	300,000	2023 оны 5-р сард	Усны тухай хууль, 2012 он
5	Хууль эрх зүйн орчны зөрчил бий болох	Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар “Ус ашиглуулах дүгнэлт” гаргуулах, зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллах	-	-	-	-	-	2023 оны 1-р улиралд	Усны тухай хууль, 2012 он
6	Хууль эрх зүйн орчны зөрчил бий болох	Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Үйлдвэрийн үйл ажиллагааны урсгал зардалд хамаарна.					Гэрээгээр тогтоосон хугацаанд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Усны тухай хууль, 2012 он</li> <li>✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 он</li> <li>✓ Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол,</li> </ul>
<b>НИЙТ</b>							<b>105,400,000</b>		

**ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	
1	БОНБНҮ-ний тайланд тусгагдсан нөхөн сэргээх төлөвлөгөө, Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд ногоон байгууламж байгуулах	Төслийн талбайд хуурай хээрийн бүсэд ургахад тохиромжтой Хайлаас- <i>Ulmus</i> -ны 2-3 настай суулгацыг тарих	Төслийн талбайд, 1 га	ш	1 га талбай-300 ш  Эгнээ хоорондын зай 4.0 м, мөр хоорондын зай 3.0 м	1500	450,000	2023 оны 04-05 дугаар сар болон 10 дугаар сард	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт  Хайлаас тарьж ургуулах гарын авлага <sup>1</sup>  MNS 5914:2008 MNS 5973:2009 MNS 5918:2008
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний нийт зардал							<b>450,000</b>		

<sup>1</sup> Хайлаас тарьж ургуулах гарын авлага - [PDF Document] (vdocuments.mx)

**ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Үйл ажиллагааны улмаас шууд нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв байхгүй.	Орон нутгийн тахилга, шүтээнтэй уул овоо, түүх соёлын дурсгалт газрыг үйлдвэрийн ажилчдад таниулах, ойр орчмын бохирдлыг цэвэрлэх	Сүмбэр сум	200	350	70,000	Хавар ба намарт	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан
<b>НИЙТ</b>						<b>70,000</b>		

**НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал / төгрөг /	Нийт зардал / төгрөг /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг.
	1	2	3	4	5	6	7	8
1	Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсад болон, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд эрүүл ахуйн нөхцөлийг хангаж, засвар үйлчилгээг жил бүр хийх, эрсдэлийн сан үүсгэх.  Төслийн талбайд байрлах ажилчид, үйлчлүүлэгчдийн ордог модон жорлонг булж, газарт ариутгал, халдваргүйжүүлэлтийг эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу хийх.	Компанийн ажилчид, үйлчлүүлэгчид  Тухайн орчинд	Байнга  1	Дотоод зардал  120,000	Дотоод зардал  120,000	2023 он  2023 оны 5 сар	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ерөнхий шаардлага.  MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ерөнхий шаардлага
2	Ослын нөхцөл хүндрэх	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах	Үйл ажиллагааны төлөвлөлтийн зардалд туссан.				2023 оны 1-р сард	-
3	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийн бүрдлийг хангаж, галын хорыг цэнэглэх	Үйл ажиллагааны төлөвлөлтийн зардалд туссан.				2023 оны 1-р сард	✓ Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он ✓ Хөдөлмөр хамгаалалын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244 : 1994



Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай"-н 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

								Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал MNS 4284:2017
<b>НИЙТ</b>							<b>120,000</b>	

**ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	<b>Ахуйн</b>	Энгийн хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд авдаг цэгүүдэд тушаах.	Үйл ажиллагааны хүрээнд	-	-	-	-	Тухай бүр	Хог хаягдлын тухай хууль – 10.2.1.
2		Хогийн цэгүүд болон тухайн орчны газрыг тогтмол ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээ авах	Үйл ажиллагааны хүрээнд	удаа	12	20,000	240,000	14 хоногт нэг удаа	Хог хаягдлын тухай хууль, 2017 он
3		Ахуйн хог хаягдлыг зохих зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжээр тээвэрлүүлэх.	Үйл ажиллагааны хүрээнд	сар	12	50,000	600,000	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль -10.2.4. Сумын ИТХ-ын 2018.12.19-ний 07 тогтоол.
4		Бохирын цооногийн дүүрэлтийг 80 хувиас хэтрүүлэхгүй соруулан зайлуулах		ш	15	80,000	1,200,000	21 хоногт нэг удаа	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924 : 2015

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай"-н 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5	Аюултай	Машин механизмаас гарсан аккумулятор, ахуйн хэрэгцээнээс гарах батерей зэргийг ангилан ялгаж түр хадгалах.	Үйл ажиллагааны хүрээнд	-	-	-	-	-	Хог хаягдлын тухай хууль – 23.1.1.
<b>Нийт</b>							<b>2,040,000</b>		

**АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийлгэх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Тайлбар	Баримтлах стандарт арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Талбайн баруун урд талаас	6-р сард	1	5,000	5,000		MNS 3298-90 MNS 5850:2019
2	Хөрсний агрохимийн найрлага	Талбайн баруун урд талаас		1	20,000	20,000		
3	Хөрсний хүнд металлын агууламж	Талбайн баруун болон зүүн талаас	7-р сард	2	25,000	50,000		
4	Хөрсний хүнд металлын агууламж	Хог хаягдлын цэгээс	7-р сард	1	25,000	25,000		
<b>Агаарын чанар</b>								
5	Хүхрийн давхар исэл	Төслийн талбайгаас	7-р сард	1	55.000			MNS 4585:2016
6	Азотын давхар исэл							
7	Нүүрстөрөгчийн дутуу исэл							

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Төмөр замын тээвэр, ачилт буулгалтын талбай"-н 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

8	PM10 том ширхэглэгт тоосонцор							
9	PM 2.5 Нарийн ширхэглэгт тоосонцор							
10	Шинжээчийн зардал	Төслийн талбай		1	260.000	260.000	-	
<b>Нийт</b>						<b>415.000</b>		

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хуваарь												Хариуцсан албан тушаалтан
			2023 оны												
			I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар	VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	105,400,000	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	Компаний захирал, байгаль орчны ажилтан
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	450,000				+	+	+							Байгаль орчны ажилтан
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	120,000	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	ХАБЭА-н ажилтан
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,040,000	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	Байгаль орчны ажилтан
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	415,000				+	+	+	+	+	+	+	+		Байгаль орчны ажилтан

**АРАВ ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2023 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг Говьсүмбэр аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	3 хувь хэвлэж хүргүүлэх	БОМТ-ний биелэлтийн үр дүнг тодорхой тусгаж, фото зургаар баримтжуулсан байх	2023 оны 11 сарын 01-ний дотор	-	Компаний захирал, Байгаль орчны ажилтан	-

**АРВАН ГУРАВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ**

№	БОМТ-ний төрлүүд	Зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	<b>105,400,000</b>
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	<b>450,000</b>
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	<b>70,000</b>
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	<b>120,000</b>
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	<b>2,040,000</b>
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	<b>415,000</b>
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
<b>2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв</b>		<b>108,495,000</b>